

**ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ СОЦИАЛИСТ ЮГАСЛАВ УЛС, БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ  
АРД УЛСЫН ХООРОНД ИРГЭН, ГЭР БҮЛ, ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАЛААР ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА  
ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ ГЭРЭЭ  
( 1981.6.8 )**

Холбооны Бүгд Найрамдах Социалист Югаслав Улсын Скупщиний Холбооны Гүйцэтгэх Вече, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар нь эрхзүйн харилцааны асуудлыг зохицуулах хоёр талын хүсэл эрмэлзлэлийг удирдлага болгон, хоёр улсын иргэдийн эрх, ашиг сонирхолыг хамгаалах явдлыг хангах зорилгоор иргэн, гэр бүл болон эрүүгийн хэргийн талаар эрхзүйн тулалцаа үзүүлэх тухай гэрээ байгуулахаар шийдвэрлэв.

Энэ зорилгоор өөрсдийн бүрэн эрхт төлөөлөгчөөр: Холбооны Бүгд Найрамдах Социалист Югаслав Улсын Скупщиний Холбооны Гүйцэтгэх Вече ....., Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлын Тэргүүлэгчид.....нарыг тус тус томилсонд тэд зохих хэлбэр, журамд бүрэн зохицсон бүрэн эрхийнхээ үнэмлэхийг солилцоод дор дурдсан зүйлийг хэлэлцэн тохиролцов.

---

<sup>2</sup> Энэхүү гэрээ нь 1981 оны 6 сарын 8-ны өдөр байгуулагдаж, 1983 оны 3 сарын 26-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болсон ба Югослав улс задарсны дараа эрх залгамжлан авсан улсуудын аль аль нь гэрээг хүчингүй болгох тухай мэдэгдээгүй учир өнөөг хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байгаа хэмээн тооцогддог.

## **НЭГДҮГЭЭР ХЭСЭГ**

### **Нийтлэг заалт**

#### **Нэгдүгээр зүйл**

##### **Эрх зүйн хамгаалалт**

Хэлэлцэн Тохиролцогч нэг Талын иргэн Хэлэлцэн Тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байхдаа хувийн болон эд хөрөнгийн эрхийн хувьд тухайн улсын иргэний нэгэн адил эрх зүйн хамгаалалт эдэлнэ. Энэ заалт нь хуулийн этгээдэд нэгэн адил хамаарна.

#### **Хоёрдугаар зүйл**

##### **Эрх зүйн туслалцаа үзүүлэх**

1. Хэлэлцэн Тохиролцогч Талууд нь энэ Гэрээнд заасан нөхцөл, журмын дагуу иргэн, гэр бүл болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлнэ.
2. Хуулийн байгууллагууд нь энэ зүйлийн 1-д заасан хэргийн талаар эрх хэмжээ бүхий бусад байгууллагад эрх зүйн туслалцаа үзүүлнэ.

#### **Гуравдугаар зүйл**

##### **Эрх зүйн туслалцааны хэмжээ**

Хэлэлцэн Тохиролцогч хоёр Тал баримт бичиг хүргүүлэх, гардуулан өгөх, хууль тогтоомж болон шүүхийн практикийн асуудлаар мэдээ солилцох, байцаан шийтгэх тодорхой үйл ажиллагаа явуулах, тухайлбал, нэгжлэг хийх, эд мөрийн баримт хүргүүлэх буюу шилжүүлэн өгөх, яллагдагчийг байцаах, гэрч, шинжээч нар болон зохигчид, бусад этгэдийг асуух, шүүхийн үзлэг, шинжилгээ явуулах замаар нэг нэгэндээ эрх зүйн туслалцаа үзүүлнэ.

#### **Дөрөвдүгээр зүйл**

##### **Харилцах журам**

Хэлэлцэн Тохиролцогч Талуудын эрх бүхий байгууллага эрх зүйн туслалцаа үзүүлэхдээ Хэлэлцэн тохиролцогч Талууд нэрийг нь дипломат шугамаар харилцан мэдэгдсэн зохих байгууллагаар дамжуулан харилцана.

#### **Тавдугаар зүйл**

##### **Харилцах хэл**

1. Хэлэлцэн Тохиролцогч Талуудын шүүх болон бусад эрх бүхий байгууллагууд хоорондоо харилцахдаа өөрийн улсын албан ёсны хэлийг хэрэглэнэ.
2. Эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай даалгавар болон түүнд хавсаргасан баримт бичгийг явуулахдаа Хэлэлцэн Тохиролцогч нөгөө Талын албан ёсны аль нэг хэлээр буюу орос хэлээр үйлдсэн баталгаатай орчуулгыг хавсаргасан байвал зохино.

#### **Зургадугаар зүйл**

##### **Даалгаврын агуулга**

Эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай даалгаварт доорхи зүйл тусгасан байвал зохино.

- a/ Даалгавар өгөгч байгууллагын нэр, мөн бололцоотой бол даалгавар хүлээн авагч байгууллагын нэр;
- b/ Эрх зүйн туслалцаа авахаар хүсэлт тавигдаж байгаа хэргийн нэр;
- c/ Зохигчдын овог, нэр, тэдний харьяалал, эрхэлдэг ажил, байнга буюу түр оршин суугаа газар, харин хуулийн этгээдийн тухайд бол байгууллагын нэр, байрладаг газар;
- d/ Талуудын төлөөлөгчдийн овог, нэр, хаяг;
- e/ Даалгаврын агуулгатай холбогдсон зайлшгүй шаардлагатай мэдээ, харин эрүүгийн хэргийн талаар бол хуулийн зүйл анги, гэмт хэргийн бүрэлдэхүүнийг тодорхойлон бичсэн байна.

#### **Долоодугаар зүйл**

##### **Даалгавар биелүүлэх журам**

1. Даалгавар хүлээн авсан байгууллага нь эрхийн туслалцаа үзүүлэх тухай даалгаварыг биелүүлэхдээ өөрийн улсын хууль тогтоомжийг хэрэглэнэ.

2. Хэрэв даалгавар хүлээн авсан байгууллага уг даалгаварыг биелүүлэх эрхгүй байвал түүнийг эрх бүхий байгууллагад шилжүүлэн өгч, энэ тухайгаа даалгавар ирүүлсэн байгууллагад мэдэгдэнэ.
3. Даалгавар хүлээн авсан байгууллага нь түүнийг өгсөн байгууллагын хүсэлтээр даалгавар биелүүлсэн газар, он, сар, өдрийг цаг тухайд нь мэдэгдэнэ.
4. Даалгавар хүлээн авсан байгууллага эрх зүйн туслалцаа үзүүлж чадахгүй бол баримт бичгийг даалгавар өгсөн байгууллагад буцаахын зэрэгцээ даалгавар биелүүлэхэд саад болж байгаа шалтгааныг мэдэгдэнэ.

#### **Наймдугаар зүйл**

#### **Баримт бичгийг гардуулан өгөх журам**

1. Хэрэв гардуулан өгөх баримт бичиг энэ Гэрээний 5 дугаар зүйлийн 2-т заасны дагуу баталгаат орчуулгатай байвал даалгавар хүлээн авсан байгууллага баримт бичиг гардуулан өгөх талаар өөрийн улсад дагаж мөрдөж байгаа журмын дагуу түүнийг гардуулна. Баримт бичиг дээрх нөхцөлийг хангахгүй байлаа ч гэсэн хэрэв хүлээн авагч этгээд түүнийг хүлээж авахаар сайн дураараа зөвшөөрвөл даалгавар хүлээн авсан байгууллага бүх баримт бичгийг түүнд гардуулж өгнө.
2. Хэрэв даалгаварт заасан хаягаар баримт бичгийг гардуулан өгөх боломжгүй бол даалгавар хүлээн авсан байгууллага хаяг тогтоох арга хэмжээ авна.

#### **Есдүгээр зүйл**

#### **Баримт бичиг гардуулсныг нотлох**

Баримт бичиг гардуулсныг түүнийг гардуулсан он, сар, өдөр, хүлээн авсан буюу гардуулсан хүний гарын үсэг бүхий баталгаа, шүүхийн тамга, эсхүл гардуулсан тухай байгууллагын нотолгоо, даалгаврыг биелүүлсэн арга, цаг хугацааг тодорхойлсноор нотолно.

#### **Аравдугаар зүйл**

#### **Баримт бичгийг өөрийн иргэдэд гардуулах**

Хэлэлцэн Тохиролцогч хоёр Тал баримт бичгийг сайн дураараа хүлээн авахыг зөвшөөрсөн өөрийн улсын иргэнд түүнийг өөрсдийн дипломат буюу консулын төлөөлөгчийн газраар дамжуулан гардуулж өгөх эрхтэй.

#### **Арваннэгдүгээр зүйл**

#### **Гэрч, шинжээчийг дуудах**

1. Хэрэв Хэлэлцэн Тохиролцогч нэг Талын нутаг дэвсгэрт оршин суугаа этгээдийг Хэлэлцэн Тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт гэрч буюу шинжээчээр байцаах шаардлага гарвал дуудлагыг Хэлэлцэн Тохиролцогч тэр Талын эрх бүхий байгууллагаар дамжуулан гардуулна.
2. Дуудагдаж буй этгээд ирэхгүй бол хүлээлгэх хариуцлагын тухай зарлан дуудах хуудсанд сануулж бичихгүй.
3. Гэрч буюу шинжээчид төлөх зардал, олгох шагналын хэмжээг зарлан дуудах хуудас гардуулах тухай хүсэлтэд заасан байвал зохино. Хүсэлт тавьсан Хэлэлцэн Тохиролцогч тал эдгээр хүмүүсийн хүсэлтээр зардлыг нөхөхийн тулд урьдчилгаа олгоно.

#### **Арванхоёрдугаар зүйл**

#### **Гэрч шинжээч нарын халдашгүй эрх**

1. Дуудлага аваад сайн дураараа Хэлэлцэн Тохиролцогч нэг Талын эрх бүхий байгууллагад очсон гэрч буюу шинжээчийн аль улсын харьяат болохыг үл харгалзан даалгавар өгсөн Хэлэлцэн Тохиролцогч талын хилийг нэвтрэн орохоосоо өмнө үйлдсэн эрүүгийн гэмт хэрэгт холбогдуулан мөрдөх буюу баривчлах, мөн шүүхээс урьд өмнө гаргасан таслан шийдвэрлэх тогтоолоор ял эдлүүлж болохгүй.
2. Гэрч буюу шинжээчийг ирүүлэх хүсэлт тавьсан байгууллагаас тэднийг цаашид байх шаардлагагүй гэж мэдэгдсэнээс хойш 15 өдрийн дотор тухайн Хэлэлцэн Тохиролцогч Талын нутаг дэвсгэрээс гарч яваагүй бол тэд энэ зүйлийн 1-д заасан баталгааг эдлэхгүй. Энэ хугацаанд гэрч буюу шинжээч өөрсдөөс нь үл шалтгаалах нөхцөл байдлаас болж даалгавар өгсөн Хэлэлцэн Тохиролцогч Талын нутаг дэвсгэрээс гарч чадаагүй саатсан хугацааг оруулахгүй.

#### **Арвангуравдугаар зүйл**

#### **Хууль тогтоомжийн тухай мэдээлэх**

Холбооны Бүгд Найрамдах Социалист Югослав Улсын Шүүн таслах хэргийг эрхлэх Холбооны эрх бүхий удирдлагын байгууллага, Бүгд найрамдах Монгол Ард Улсын Дээд шүүх нь аль нэгийнхээ хүсэлтээр

өөрсдийн оронд дагаж мөрдөж байгаа бөгөөд дагаж мөрдөж байсан хууль тогтоомжийн талаар, түүнчлэн шүүхийн практикийн эрх зүйн зарим асуудлаар мэдээлэл өгч байна.

**Арвандөрөвдүгээр зүйл**  
**Эрх зүйн туслалцаа үзүүлэхтэй холбогдсон зардал**

Даалгавар хүлээн авсан Хэлэлцэн Тохиролцогч Тал нь эрх зүйн туслалцаа үзүүлэхэд гарсан зардал төлөхийг шаардахгүй. Хэлэлцэн Тохиролцогч Талууд өөрийн нутаг дэвсгэр дээр эрхзүйн туслалцаа үзүүлэхтэй холбогдон гарсан бүх зардлыг өөрсдөө хариуцна.

**Арвантавдугаар зүйл**  
**Хувийн байдлын тухай баримт бичиг солилцох**

1. Хэлэлцэн Тохиролцогч Тал нь Хэлэлцэн Тохиролцогч нөгөө Талын иргэний төрөлт, гэрлэлт болон нас баралттай холбогдсон иргэний байдлын бүртгэлийн актаас хэсэгчлэн авсан хуулбарыг Хэлэлцэн Тохиролцогч нөгөө Талд илгээж байна.
2. Энэ зүйлийн 1-д заасан хуулбарыг Хэлэлцэн Тохиролцогч нөгөө Талын дипломат буюу консулын төлөөлөгчийн газарт хураамж, зардал авалгүйгээр илгээнэ.

**Арванзургадугаар зүйл**  
**Албан баримт бичгийн нотлох чадвар**

Хэлэлцэн Тохиролцогч нэг Талын нутаг дэвсгэрт үйлдсэн баримт бичиг нь Хэлэлцэн Тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт тэдний албан баримт бичгийн нэгэн адил хүчинтэй байна.

**Арвандолдугаар зүйл**  
**Эрх зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзах**

Хэрэв эрх зүйн туслалцаа үзүүлэх нь даалгавар хүлээн авсан Хэлэлцэн Тохиролцогч Талын тусгаар тогтнол, аюулгүй байдалд хохирол учруулахаар буюу хууль тогтоомжийн үндсэн зарчимд харшлахаар байвал Хэлэлцэн Тохиролцогч нөгөө Талд эрх зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзаж болно.

**ХОЁРДУГААР ХЭСЭГ**  
**Иргэн, гэр бүлийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх**

**1. Шүүхийн зардал**  
**Шүүхийн зардал төлөхөөс чөлөөлөх**

**Арваннаймдугаар зүйл**

Хэлэлцэн Тохиролцогч хоёр Талын аль нэгний иргэн Хэлэлцэн Тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байгаа бөгөөд тухайн Талын шүүхийн ажиллагаанд оролцвол түүнд гадаадын харьяат буюу тухайн улсад байнга буюу түр оршин суудаггүй гэсэн үндэслэлээр шүүхийн зардал төлөх үүрэг оногдуулж болохгүй.

**Арванесдүгээр зүйл**

1. Энэ Гэрээний 18 дугаар зүйлд зааснаар шүүхийн зардал төлөхөөс чөлөөлөгдсөн иргэн Хэлэлцэн Тохиролцогч нэг Талын нутаг дэвсгэрт хуулийн хүчин төгөлдөр болсон шийдвэрээр шүүхийн зардал төлөх үүрэг оногдсон бол Хэлэлцэн Тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэр дээр зохих шүүх уг зардлыг хүсэлтийн нь дагуу үнэ төлбөргүй албадан гаргуулахыг зөвшөөрнө.
2. Лавлагаа, орчуулга, баримт бичгийн баталгаа бэлтгэхтэй холбогдсон зардлыг шүүхийн зардалд тооцно.

**Хорьдугаар зүйл**

1. Шүүхийн зардал төлөх тухай шийдвэрийг албадан биелүүлэхийг зөвшөөрч байгаа шүүх нь уг шийдвэр нь хуулийн хүчин төгөлдөр болсон эсэх, түүнийг биелүүлбэл зохих эсэхийг шалган үзсэнээр ажлаа хязгаарлана.
2. Албадан биелүүлэхийг зөвшөөрөх тухай хүсэлт болон хавсралт баримт бичгийн талаар энэ Гэрээний 57 зүйлийг баримтална.

**Хориннэгдүгээр зүйл**

Энэ Гэрээний 20 дугаар зүйлд заасан албадан биелүүлэхийг зөвшөөрөх тухай хүсэлтийг шийдвэрлэхдээ энэ Гэрээний 58 дугаар зүйлийг баримтална.

### **Хоринхоёрдугаар зүйл**

Энэ Гэрээний 19 дүгээр зүйлд дурдсан лавлагаа, орчуулга бэлтгэх, баримт бичгийн баталгаа хийхтэй холбогдсон зардлын хэмжээг уг хэргийг авч хэлэлцсэн анхан шатны шүүх буюу албадан биелүүлэхийг зөвшөөрөх эрх бүхий шүүх тодорхойлно. Албадан биелүүлэхтэй холбогдсон зардлын хэмжээг албадан биелүүлэхийг зөвшөөрөх эрх бүхий шүүх тодорхойлно.

### **Шүүхийн зардлаас чөлөөлөх Хорингуравдугаар зүйл**

Хэлэлцэн Тохиролцогч нэг Талын иргэнийг Хэлэлцэн Тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт шүүхийн хураамж, зардлаас өөрийнхөө иргэний нэгэн адил нөхцөл, хэмжээгээр чөлөөлнө.

### **Хориндөрөвдүгээр зүйл**

1. Хувийн болон гэр бүлийн байдал, түүнчлэн цалин хөлс, эд хөрөнгийн тухай баримт бичгийг хүсэлт гаргасан иргэн нутаг дэвсгэрт нь байнга буюу түр оршин суугаа Хэлэлцэн Тохиролцогч Талын эрх бүхий байгууллагаас олгоно.
2. Хэрэв хүсэлт гаргасан этгээд Хэлэлцэн Тохиролцогч Талын нутаг дэвсгэрт байнга буюу түр оршин суудаггүй бол түүнийг харьяалах улсын дипломат буюу консулын төлөөлөгчийн газраас олгосон баримт бичгийг баримтална.
3. Шүүхийн хураамж, зардлаас чөлөөлүүлэх тухай хүсэлтийг шийдвэрлэж байгаа шүүх ирүүлсэн баримт бичгийн үндэслэлтэй эсэхийг шалгаж, нэмэгдэл мэдээ сэлтийг шаардаж болно.

### **Хоринтавдугаар зүйл**

1. Хэлэлцэн Тохиролцогч нэг Талын иргэн Хэлэлцэн Тохиролцогч нөгөө Талын эрх бүхий шүүхэд шүүхийн хураамж, зардлаас чөлөөлүүлэх тухай хүсэлт гаргахдаа байнга буюу түр оршин суугаа газрынхаа эрх бүхий шүүхэд хүсэлтээ амаар тавьж болох бөгөөд уг шүүх нь хүсэлтийг протоколд тусгаж авна. Шүүх нь протоколыг энэ Гэрээний 24 дүгээр зүйлийн 1-д заасны дагуу гаргасан лавлагаа болон хүсэлт гаргасан этгээдээс ирүүлсэн бусад баримт бичигтэй хамтатган Хэлэлцэн Тохиролцогч нөгөө Талын шүүхэд хүргүүлнэ.
2. Шүүхийн хураамж, зардлаас чөлөөлүүлэх тухай хүсэлтийн зэрэгцээгээр нэхэмжлэлээр буюу өөр бусад үндэслэлээр байцаан шийтгэх ажиллагаа үүсгэн явуулах тухай хүсэлт гаргаж болно.

### **2.Хувийн горим Хоринзургадугаар зүйл Эрх эдлэх, үүрэг бий болгох чадвар**

Иргэний эрх эдлэх, үүрэг бий болгох чадварыг уг иргэнийг харьяалах Хэлэлцэн Тохиролцогч Талын хууль тогтоомжоор тогтооно.

### **Хориндолдугаар зүйл Эрх эдлэх, үүрэг бий болгох чадварыг хасах буюу хязгаарлах**

1. Иргэний эрх эдлэх, үүрэг бий болгох чадварыг хасах буюу хязгаарлахдаа уг иргэнийг харьяалах Хэлэлцэн Тохиролцогч Талын байгууллага нь өөрийн улсын хууль тогтоомжийг хэрэглэж, харьяалан шийдвэрлэнэ.
2. Иргэний эрх эдлэх, үүрэг бий болгох чадварыг сэргээн тогтоох тохиолдолд энэ зүйлийн 1-д заасан журмыг хэрэглэнэ.
3. Хэрэв Хэлэлцэн Тохиролцогч нэг Талын эрх бүхий байгууллага нутаг дэвсгэртээ байнга буюу түр оршин суугаа Хэлэлцэн Тохиролцогч нөгөө Талын иргэний эрх эдлэх, үүрэг бий болгох чадварыг хасах буюу хязгаарлах шалтгаантай гэж үзвэл энэ тухай Хэлэлцэн Тохиролцогч нөгөө Талын дипломат буюу консулын төлөөлөгчийн газарт мэдэгдэж шаардлагатай бол уг этгээдийг болон түүний эд хөрөнгийг хамгаалах зохих арга хэмжээ авна.
4. Хэрэв эрх эдлэх, үүрэг бий болгох чадварыг хасах буюу хязгаарлах асуудлыг тухайн иргэнийг харьяалах Хэлэлцэн Тохиролцогч Талын эрх бүхий байгууллага зургаан сарын дотор авч хэлэлцэхгүй буюу хариу өгөхгүй бол Хэлэлцэн Тохиролцогч Талын эрх бүхий байгууллага нь Хэлэлцэн Тохиролцогч хоёр талын

хууль тогтоомжийг баримтлан шийдвэрлэх бөгөөд уг шийдвэрээ Хэлэлцэн Тохиролцогч нөгөө Талын эрх бүхий байгууллагад явуулна.

### **Хориннаймдугаар зүйл Сураггүй алга болсон буюу нас барсанд тооцох**

1. Иргэнийг сураггүй алга болсон буюу нас барсанд тооцох, түүнчлэн нас барсан үйл баримтыг тогтоох тухай хэргийг сүүлчийн мэдээ баримтаар уг иргэнийг амьд ахуй цагт нь харьяалж байсан Хэлэлцэн Тохиролцогч Талын шүүх шийдвэрлэх эрх бүхий байна.
2. Хэлэлцэн Тохиролцогч нэг Талын хууль тогтоомжоор эрх, ашиг сонирхол нь хамгаалагдсан бөгөөд тухайн Талын нутаг дэвсгэр дээр оршин суугаа сонирхогч этгээдийн хүсэлтээр энэ Хэлэлцэн Тохиролцогч Талын шүүх, Хэлэлцэн Тохиролцогч нөгөө Талынхаа иргэнийг сураггүй алга болсон буюу нас барсанд тооцох, түүнчлэн нас барсан үйл баримтыг тогтоож болно.
3. Энэ зүйлийн 2-т заасны дагуу иргэнийг сураггүй алга болсон буюу нас барсанд тооцох, түүнчлэн нас барсан шалтгааныг тогтоохдоо сураггүй алга болсон буюу нас барсан иргэн харьяат нь байсан Хэлэлцэн Тохиролцогч Талын, эсхүл шүүх нь шийдвэр гаргаж байгаа Хэлэлцэн Тохиролцогч Талын хууль тогтоомжийг баримтална.
4. Энэ зүйлийн 2-т заасны дагуу гаргасан шийдвэр зөвхөн шүүх нь уг шийдвэрийг гаргасан Хэлэлцэн Тохиролцогч Талын нутаг дэвсгэр дээр хууль зүйн үр дагавар бүхий байна.
5. Энэ зүйлийн 1-д заасан шүүх тухайн хэргийн талаар шийдвэр гаргасан бол сонирхогч этгээдийн хүсэлтээр энэ зүйлийн 2-т заасны дагуу нутаг дэвсгэртээ шийдвэр гаргасан Хэлэлцэн Тохиролцогч Талын эрх бүхий шүүх нь шаардлагатай үед шийдвэрээ хүчингүй болгох буюу өөрчилнө.

### **3. Гэр бүлийн хэрэг Хоринесдүгээр зүйл Гэрлэх**

1. Гэрлэх нөхцөлийг гэрлэхийг хүсэгч тус бүр харьяат нь байгаа Хэлэлцэн Тохиролцогч Талын хуулиар тодорхойлно.
2. Энэ зүйлийн 1-д дурдсан нь нутаг дэвсгэр дээр нь гэрлэж байгаа Хэлэлцэн Тохиролцогч Талын хууль тогтоомжийн гэрлэхийг хориглосон заалтыг хэрэглэхийг үгүйсгэхгүй.
3. Гэрлэх хэлбэрийг нутаг дэвсгэрт нь гэрлэж байгаа Хэлэлцэн Тохиролцогч Талын хууль тогтоомжоор тодорхойлно.
4. Хэлэлцэн Тохиролцогч Талуудын дипломат буюу консулын төлөөлөгчийн газар гэрлэхийг хүсэгчид хоёулаа тухайн талын иргэд байвал гэрлэхийг бүртгэж болно.

### **Гучдугаар зүйл Гэрлэгсдийн хувийн болон эд хөрөнгө-эрх зүйн харилцаа**

1. Гэрлэгсдийн хувийн болон эд хөрөнгө-эрх зүйн харилцааг эхнэр, нөхрийн харьяат нь байгаа Хэлэлцэн Тохиролцогч Талын хууль тогтоомжоор зохицуулна.
2. Хэрэв эхнэр, нөхрийн хэн нэг нь Хэлэлцэн Тохиролцогч нэг Талын харьяат, нөгөө нь Хэлэлцэн Тохиролцогч нөгөө Талын харьяат бол тэдний хувийн болон эд хөрөнгө-эрх зүйн харилцааг тэд хамгийн сүүлд хамт оршин сууж байгаа буюу сууж байсан Хэлэлцэн Тохиролцогч Талын хууль тогтоомжоор зохицуулна.

### **Гучиннэгдүгээр зүйл Гэрлэлтийг цуцлах**

1. Гэрлэлтийг цуцлахдаа гэрлэлт цуцлуулах хэргийг үүсэх үед эхнэр, нөхөр хоёр харьяат нь байсан Хэлэлцэн Тохиролцогч Талын хууль тогтоомжийг баримтална.
2. Хэрэв эхнэр, нөхөр хоёр гэрлэлтээ цуцлуулах хүсэлт гаргах үедээ өөр өөр харьяалалтай байвал гэрлэлт цуцлах явдлыг тэд хамгийн сүүлд хамт оршин сууж байгаа буюу сууж байсан Хэлэлцэн Тохиролцогч Талын хууль тогтоомжоор тодорхойлно.

### **Гучинхоёрдугаар зүйл Гэрлэснийг хүчингүйд тооцох**

Гэрлэснийг хүчингүйд тооцохдоо гэрлэлтийг бүртгэсэн Хэлэлцэн Тохиролцогч Талын хууль тогтоомжийг баримтална.

**Гучингуравдугаар зүйл**  
**Гэрлэлтийн хэрэг шийдвэрлэх харьяалал**

Энэ Гэрээний 30-32 дугаар зүйлд дурдсан асуудлыг гэрлэгсдийг харьяалах Хэлэлцэн Тохиролцогч Талын шүүх, эсхүл гэрлэгсэд нутаг дэвсгэр дээр нь хамгийн сүүлд хамт оршин сууж байгаа буюу сууж байсан Хэлэлцэн Тохиролцогч Талын шүүх харьяалан шийдвэрлэнэ.

**Гучиндөрөвдүгээр зүйл**  
**Эцэг, эх, хүүхдийн эрх зүйн харилцаа**

1. Эцэг, эх, хүүхдийн эрх зүйн харилцааг тэднийг харьяалах Хэлэлцэн Тохиролцогч Талын хууль тогтоомжоор зохицуулна.
2. Хэрэв эцэг, эх болон хүүхэд өөр өөр харьяалалтай бол тэдний харилцааг хүүхэд харьяат нь байгаа Хэлэлцэн Тохиролцогч Талын хууль тогтоомжоор зохицуулна.
3. Хэрэв хүүхэд төрөх үед түүний эцэг, эх нь гэр бүл болоогүй байсан бол тэдний харилцааг харьяалах Хэлэлцэн Тохиролцогч Талын хууль тогтоомжоор, хэрэв тэд өөр өөр харьяалалтай бол нь хамгийн сүүлд хамт оршин сууж байгаа буюу сууж байсан Хэлэлцэн Тохиролцогч Талын хууль тогтоомжоор тус тус зохицуулна.

**Гучинтавдугаар зүйл**  
**Эцэг, эхийг тогтоох буюу маргах тухай**

Хүүхдийн эцэг, эхийг тогтоох тухай болон энэ талаар гарсан маргаан, мөн хүүхэд уг гэр бүлээс төрснийг тогтоох тухай хэргийг хүүхдийг харьяалах Хэлэлцэн Тохиролцогч Талын хууль тогтоомжийг баримтлан шийдвэрлэнэ.

**Гучинзургадугаар зүйл**  
**Эцэг, эх, хүүхдийн харилцааны тухай хэргийн харьяалал**

1. Энэ Гэрээний 34, 35 дугаар зүйлд заасан хэргийг хүүхдийн харьяалах Хэлэлцэн Тохиролцогч Талын шүүх харьяалан шийдвэрлэнэ.
2. Хэрэв нэхэмжлэгч, хариуцагч нь Хэлэлцэн Тохиролцогч аль нэг Талын нутаг дэвсгэрт амьдарч байгаа бол Хэлэлцэн Тохиролцогч Талын шүүх энэ Гэрээний 34, 35 дугаар зүйлд заасан харьяаллыг баримтлан шийдвэрлэнэ.

**Гучиндолдугаар зүйл**  
**Хүүхэд үрчлэх нөхцөл**

1. Хүүхэд үрчлэх нөхцөлийг үрчлэн авагч болон үрчлүүлэгчийг харьяалах Хэлэлцэн Тохиролцогч Талын хууль тогтоомжоор, хэрэв үрчлэн авагч болон үрчлүүлэгч нь өөр өөр харьяалалтай бол үрчлэн авагч болон үрчлүүлэгчийг харьяалах Хэлэлцэн Тохиролцогч хоёр Талын хууль тогтоомжоор зохицуулна.
2. Хэрэв хүүхэд үрчлэн авах эхнэр, нөхөр хоёр өөр өөр харьяалалтай бол үрчлэн авах нөхцөлийг Хэлэлцэн Тохиролцогч хоёр Талын хууль тогтоомжоор зохицуулна.
3. Энэ зүйлийн заалтыг үрчлэлтийг хүчингүй болгоход нэгэн адил баримтална.

**Гучиннаймдугаар зүйл**  
**Үрчлэлтийн тухай хэргийн харьяалал**

Үрчлэлтийн болон үрчлэлтийг хүчингүй болгох тухай хэргийг үрчлэн авагч, үрчлүүлэгчийг харьяалах Хэлэлцэн Тохиролцогч Талын байгууллага, эсхүл тэд хамгийн сүүлд нутаг дэвсгэр дээр нь хамт оршин сууж байгаа буюу сууж байсан Хэлэлцэн Тохиролцогч Талын байгууллага харьяалан шийдвэрлэнэ.

**4. Асран хамгаалах, харгалзан дэмжих**

**Гучинесдүгээр зүйл**  
**Асран хамгаалах, харгалзан дэмжихийг тогтоох**

1. Асран хамгаалах, харгалзан дэмжихийг тогтоох, хүчингүй болгох асуудлыг асран хамгаалуулах буюу харгалзан дэмжүүлэгч (цаашид “асруулагч” гэж нэрлэнэ) харьяат нь байгаа Хэлэлцэн Тохиролцогч Талын шүүх өөрийн улсын хууль тогтоомжийг баримтлан шийдвэрлэнэ.

2. Асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон асруулагчдын эрх зүйн харилцааг асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг томилсон байгууллагын харьяалах Хэлэлцэн Тохиролцогч Талын хууль тогтоомжоор зохицуулна.
3. Асран хамгаалах, харгалзан дэмжихийг хүлээн авах үүргийг асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг харьяалах Хэлэлцэн Тохиролцогч Талын хууль тогтоомжоор зохицуулна.
4. Асран хамгаалах, харгалзан дэмжихийг тогтоох буюу хүчингүй болгох тухай Хэлэлцэн Тохиролцогч аль нэг Талын байгууллагаас өөрийн иргэнтэй холбогдуулан гаргасан шийдвэрийг Хэлэлцэн Тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт хүлээн зөвшөөрнө.

**Дөчдүгээр зүйл**  
**Түр хамгаалах арга хэмжээ**

1. Хэрэв Хэлэлцэн Тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байнга буюу түр оршин суугаа, эсхүл эд хөрөнгө нь байгаа Хэлэлцэн Тохиролцогч нэг Талын иргэний эрх, ашиг сонирхолыг хамгаалах шаардлага гарвал тухайн Хэлэлцэн Тохиролцогч Талын эрх бүхий байгууллагаас уг иргэн харьяат нь байгаа Хэлэлцэн Тохиролцогч нөгөө Талын дипломат буюу консулын төлөөлөгчийн газарт энэ тухай нэн даруй мэдэгдэнэ.
2. Хэлэлцэн Тохиролцогч нөгөө Талын эрх бүхий байгууллага хойшлуулшгүй тохиолдолд өөрийн улсын дотоодод дагаж мөрдөж байгаа хууль тогтоомжийн дагуу урьдчилж арга хэмжээ авч болох ба энэ тухайгаа уг зүйлийн 1-д зааснаар Хэлэлцэн Тохиролцогч нөгөө Талын дипломат буюу консулын төлөөлөгчийн газарт нэн даруй мэдэгдэнэ. Ийнхүү авсан бүх арга хэмжээ нь эрх бүхий байгууллагаас өөр шийдвэр гаргах хүртэл хүчин төгөлдөр байна.

**Дөчиннэгдүгээр зүйл**  
**Асран хамгаалах, харгалзан дэмжихийг шилжүүлэх**

1. Энэ Гэрээний 39 дүгээр зүйлийн 1-д заасан Хэлэлцэн Тохиролцогч талын эрх бүхий байгууллага нь Хэлэлцэн Тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт асруулагч байнга буюу түр оршин суугаа, эсхүл түүний эд хөрөнгө нь тэнд байгаа бол Хэлэлцэн Тохиролцогч Талын тухайн байгууллагад асран хамгаалах буюу харгалзан дэмжих явдлыг шилжүүлж болно. Асран хамгаалах, харгалзан дэмжихийг шилжүүлсэн нь хүсэлт хүлээн авсан Хэлэлцэн Тохиролцогч Талын тухайн байгууллага асран хамгаалах, харгалзан дэмжих явдлыг өөртөө хүлээн авснаа хүсэлт тавьсан Хэлэлцэн Тохиролцогч Талын тухайн байгууллагад мэдэгдсэнээр хүчин төгөлдөр болно.
2. Энэ зүйлийн 1-д зааснаар асран хамгаалах, харгалзан дэмжих явдлыг хүлээн авсан Хэлэлцэн Тохиролцогч Талын байгууллага уг асуудлыг өөрийн улсын хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх боловч асруулагчийн хувийн горимтой холбогдсон асуудлаар шийдвэр гаргах эрхгүй.

**5. Өв залгамжлах**  
**Дөчинхоёрдугаар зүйл**  
**Тэгш эрхийн зарчим**

1. Хэлэлцэн Тохиролцогч нэг Талын иргэн Хэлэлцэн Тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байгаа эд хөрөнгийг хууль ёсоор буюу гэрээслэлээр өвлөн авахад Хэлэлцэн Тохиролцогч тухайн Талын иргэнтэй адил тэгш эрх эдэлнэ.
2. Хэлэлцэн Тохиролцогч нэг Талын иргэн Хэлэлцэн Тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байгаа өөрийн эд хөрөнгийг гэрээслэлийн дагуу захиран зарцуулж болно.
3. Хэлэлцэн Тохиролцогч нэг талын иргэн Хэлэлцэн Тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт өв залгамжлан авсан үл хөдлөх эд хөрөнгөө эрх зүйн хэлцлийн үндсэн дээр захиран зарцуулж болно.

**Дөчингуравдугаар зүйл**  
**Өв залгамжлалыг зохицуулах хууль тогтоомж**

1. Хөдлөх эд хөрөнгө өвлөх эрхийг өвлүүлэгч нас барах үедээ харьяат нь байсан Хэлэлцэн Тохиролцогч Талын хууль тогтоомжоор зохицуулна.
2. Үл хөдлөх эд хөрөнгө өвлөх эрхийг уг эд хөрөнгө нутаг дэвсгэрт нь байгаа Хэлэлцэн Тохиролцогч Талын хууль тогтоомжоор зохицуулна. Ямар эд хөрөнгийг хөдлөх, үл хөдлөх гэж үзэхийг уг эд хөрөнгө нутаг дэвсгэрт байгаа Хэлэлцэн Тохиролцогч Талын хууль тогтоомжоор тодорхойлно.

**Дөчиндөрөвдүгээр зүйл**  
**Эзэнгүй эд хөрөнгө**



Эзэнгүй үлдсэн хөдлөх эд хөрөнгө нь өвлүүлэгч нас барах үед харьяат нь байсан Хэлэлцэн Тохиролцогч Талын, үл хөдлөх эд хөрөнгө бол уг зүйл нутаг дэвсгэрт нь байгаа Хэлэлцэн Тохиролцогч Талын орлого болно.

#### **Дочинтавдугаар зүйл Гэрээслэл**

1. Гэрээслэл үйлдэх буюу хүчингүй болгох чадвар болон хүсэл санаагаа хангалтгүй илэрхийлснээр үүссэн маргааныг өвлүүлэгч гэрээслэл үйлдэх буюу хүчингүй болгох үед харьяат нь байсан Хэлэлцэн Тохиролцогч Талын хууль тогтоомжоор тодорхойлно.
2. Гэрээслэлийн хэлбэр, түүнийг хүчингүй болгох явдлыг өвлүүлэгч гэрээслэл үйлдэх буюу хүчингүй болгох үедээ харьяат нь байсан Хэлэлцэн Тохиролцогч Талын хууль тогтоомжоор тодорхойлно. Гэрээслэл үйлдэх буюу хүчингүй болгох хэлбэр нь нутаг дэвсгэрт нь гэрээслэл үйлдсэн буюу хүчингүй болгосон Хэлэлцэн Тохиролцогч Талын хууль тогтоомжийн дагуу үйлдсэн бол хүчин төгөлдөр байна.

#### **Дочинзургадугаар зүйл. Нас барсан тухай мэдэгдэх**

1. Хэрэв Хэлэлцэн Тохиролцогч нэг Талын нутаг дэвсгэрт Хэлэлцэн Тохиролцогч нөгөө Талын иргэн нас барвал энэ талаар зохих байгууллагаас нас барагчийн өв залгамжлагчийн тухай, тэдний байнга буюу түр оршин суугаа газар, өв хөрөнгийн хэмжээ, үнэ, түүнчлэн гэрээслэл байгаа эсэх талаар мэдэгдэж байгаа бүх мэдээ сэлтийг Хэлэлцэн Тохиролцогч нөгөө Талын дипломат буюу консулын төлөөлөгчийн газарт нэн даруй мэдэгдэнэ. Хэлэлцэн Тохиролцогч нэг Талын зохих байгууллага нь Хэлэлцэн Тохиролцогч нөгөө талын иргэн Хэлэлцэн Тохиролцогч хоёр Талын нутаг дэвсгэрийн гадна нас барсан бөгөөд өөрийн нутаг дэвсгэр дээр эд хөрөнгө нь үлдсэн тухай мэдээ сэлт авсан тохиолдолд энэ журмыг нэг адил хэрэглэнэ.
2. Хэрэв нас барсан тухай мэдээг дипломат буюу консулын төлөөлөгчийн газар түрүүлж авсан бол өв хөрөнгийг хамгаалах арга хэмжээ авах эрх бүхий байгууллагад энэ тухайгаа мэдэгдвэл зохино.

#### **Дочиндолдугаар зүйл Өв хөрөнгийг хамгаалах арга хэмжээ**

1. Хэрэв Хэлэлцэн Тохиролцогч нэг Талын иргэн Хэлэлцэн Тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт өв залгамжлуулах эд хөрөнгөө үлдээсэн бол уг талын эрх бүхий байгууллага өөрийн улсад дагаж мөрдөж байгаа хууль тогтоомжийн дагуу эд хөрөнгийг нь хамгаалах, зохицуулах шаардлагатай арга хэмжээ авна.
2. Энэ зүйлийн 1-д заасны дагуу авч байгаа арга хэмжээний талаар Хэлэлцэн Тохиролцогч нөгөө Талын дипломат буюу консулын төлөөлөгчийн газарт нэн даруй мэдэгдэх бөгөөд эдгээр газар нь өөрсдөө шууд буюу бүрэн эрхтэй төлөөлөгчөөрөө дамжуулан эд хөрөнгийг хамгаалах арга хэмжээнд оролцож болохоос гадна авсан арга хэмжээг зогсоох, өөрчлөх, хойшлуулах санал тавьж болно.

#### **Дочиннаймдугаар зүйл Өв залгамжлах хэргийн талаар дипломат буюу консулын төлөөлөгчийн газрын эдлэх эрх**

Хэлэлцэн Тохиролцогч нэг Талын дипломат буюу консулын төлөөлөгчийн газар нь өв залгамжлалын хэрэгт өөрийн харьяат иргэнийг эзгүй байх буюу тэр аль нэг этгээдийг уг хэрэгт оролцуулах итгэмжлэл олгоогүй үед тусгайлсан итгэмжлэлгүйгээр Хэлэлцэн Тохиролцогч нөгөө Талын зохих байгууллагад өөрийн харьяат иргэнийг төлөөлөн оролцох эрхтэй.

#### **Дочинесдүгээр зүйл Өв хөрөнгийг шилжүүлэн өгөх**

Өв залгамжлалын хэргийн байцаан шийтгэх ажиллагааны эцэст хөдлөх эд хөрөнгө (эд зүйл)-ийг Хэлэлцэн Тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байнга буюу түр оршин суугаа өв залгамжлагч иргэнд шилжүүлэх хэрэгтэй бол уг эд хөрөнгийг тухайн иргэнийг харьяалах Хэлэлцэн Тохиролцогч Талын дипломат буюу консулын төлөөлөгчийн газарт дор дурдсан нөхцөлд шилжүүлнэ. Үүнд:

- а/ өв залгамжлалын эд хөрөнгө нутаг дэвсгэрт нь байгаа орны хууль тогтоомжид зааснаар өв залгамжлагчийг нэхэмжлэлийн шаардлага гаргуулахаар эрх хэмжээ бүхий байгууллагаас дуудсан бол;
- б/ өв залгамжлалтай холбогдсон хураамжийг төлсөн буюу нэхэмжлэлийг нь хангасан, эсхүл хангах баталгаа буй болгосон бол;
- в/ эд хөрөнгийг авч явахыг эрх бүхий байгууллага зөвшөөрсөн бол.

**Тавьдугаар зүйл**  
**Өв залгамжлалын тухай хэргийн харьяалал**

1. Энэ Гэрээгээр өөр журам тогтоогоогүй бол хөдлөх эд хөрөнгө өв залгамжлуулах тухай хэргийг өв залгамжлуулагч нас барах үедээ иргэн нь байсан Хэлэлцэн Тохиролцогч Талын байрууллага харьяалан шийдвэрлэнэ.
2. Үл хөдлөх эд хөрөнгө өв залгамжлуулах тухай хэргийг уг эд хөрөнгө нутаг дэвсгэрт нь байгаа Хэлэлцэн Тохиролцогч Талын байгууллага харьяалан шийдвэрлэнэ.
3. Өв залгамжлах эрх зүйн ундсэн дээр үүссэн маргааныг шийдвэрлэхэд энэ зүйлийн 1, 2-т дурдсан зохих заалтыг хэрэглэнэ.
4. Хэлэлцэн Тохиролцогч аль нэг Талын иргэн нас барсны дараа түүний өвлөгдвөл зохих хөдлөх эд хөрөнгө Хэлэлцэн Тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байгаа үед хэрэв бүх өв залгамжлагчид зөвшөөрвөл өв залгамжлагч буюу хувь авагчийн хүсэлтээр өв залгамжлалын тухай хэргийг Хэлэлцэн Тохиролцогч уг Талын эрх бүхий байгууллага хэлэлцэнэ.

**Тавиннэгдүгээр зүйл**  
**Гэрээслэлийг нээх, зарлах**

1. Нутаг дэвсгэрт нь гэрээслэл байгаа Хэлэлцэн Тохиролцогч Талын гэрээслэлийн асуудлыг эрхэлсэн байгууллага уг гэрээслэлийг нээж, зарлах эрхтэй.
2. Хэрэв Тохиролцогч аль нэг Талын байгууллага Хэлэлцэн Тохиролцогч нөгөө Талын иргэний гэрээслэлийг зөвшөөрсөн бол гэрээслэлийн батлагдсан хуулбар, гэрээслэлийн байдлын тухай холбогдох материал, гэрээслэлийг зарласан тухай протоколын хуулбар, хэрэв шаардсан бол гэрээслэлийн эх хувийг өв залгамжлагч харьяат нь байгаа Хэлэлцэн Тохиролцогч Талын эрх бүхий байгууллагад шилжүүлнэ. Энэ заалтыг Хэлэлцэн Тохиролцогч нөгөө Талын өв залгамжлалын тухай асуудлыг хэлэлцэх эрх бүхий байгууллага нэгэн адил хэрэглэнэ.

**Шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх**

**Тавинхоёрдугаар зүйл**  
**Хүлээн зөвшөөрч, биелүүлбэл зохих шүүхийн шийдвэрүүд**

1. Хэлэлцэн Тохиролцогч Талууд энэ Гэрээнд заасны дагуу Хэлэлцэн Тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт гарсан дараах шийдвэрийг өөрийн нутаг дэвсгэр дээр хүлээн зөвшөөрч, биелүүлнэ. Үүнд:
  - а/ иргэний болон гэр бүлийн хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр;
  - б/ хөндлөнгийн шүүхийн шийдвэр;
  - в/ эд хөрөнгө-эрх зүйн асуудлаар шаардлага тавьсан (хохирол нөхөн төлөх, эд зүйлсийг буцаан олгох зэрэг) эрүүгийн хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр.
2. Түүнчлэн энэ зүйлийн 1-ийн "а", "б"-д дурдсан эд хөрөнгийн шаардлагын талаар ердийн шүүх буюу хөндлөнгийн шүүхээс баталсан эвлэрсэн хэлцлийг багтааж ойлгоно.
3. Хэлэлцэн Тохиролцогч аль нэг Талын өв залгамжлалын хэргийн талаар байцаан шийтгэх ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагаас энэ Хэлэлцэн Тохиролцогч Талын зохих журмын дагуу өв залгамжлалын асуудлаар гаргасан шийдвэрийг энэ зүйлийн 1-ийн "а"-д заасан шүүхийн шийдвэртэй адилтгаж үзнэ.

**Тавингуравдугаар зүйл**  
**Шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэх нөхцөл**

- Энэ Гэрээний 52 дугаар зүйлд заасан шийдвэрийг дараахи нөхцөлд хүлээн зөвшөөрч, биелүүлнэ:
- а/ нутаг дэвсгэрт нь шийдвэр гарсан Хэлэлцэн Тохиролцогч Талын хууль тогтоомжийн дагуу уг шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон буюу биелүүлэх ёстой байвал;
  - б/ нутаг дэвсгэрт нь шийдвэр гарсан Хэлэлцэн Тохиролцогч Талын шүүх нь уг шийдвэрийг нутаг дэвсгэр дээрээ хүлээн зөвшөөрч, биелүүлэх ёстой Хэлэлцэн Тохиролцогч Талын хууль тогтоомжийн дагуу тийм шийдвэр гаргах эрх бүхий байвал;
  - в/ шүүхийн шийдвэр өөрийн нь эсрэг гарсан зохигч (түүний төлөөлөгч) шүүн таслах ажиллагаанд оролцоогүй тохиолдолд шүүхийн шийдвэр гаргасан Хэлэлцэн Тохиролцогч Талын хууль тогтоомжийн дагуу тэдэнд хэрэг хэлэлцэх тухай зохих ёсоор, цаг хугацаанд нь мэдэгдсэн, эсхүл байцаан шийтгэх ажиллагаанд оролцох эрхийн чадваргүй тохиолдолд төлөөлөгчөө оролцуулах боломжийг зохих ёсоор хангасан бол;

г/ шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлбэл зохих Хэлэлцэн Тохиролцогч Талын эрх бүхий шүүх нь уг хэргийн талаар тухайн зохигч оролцсон маргааныг шийдвэрлэсэн хуулийн хүчин төгөлдөр шийдвэр байхгүй буюу уг Хэлэлцэн Тохиролцогч Талын шүүхэд тухайн хэргийн талаар байцаан шийтгэх ажиллагаа үүнээс өмнө явуулж эхлээгүй бол;

д/ шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэх нь түүнийг хүлээн зөвшөөрч, биелүүлбэл зохих Хэлэлцэн Тохиролцогч Талын хууль тогтоомжийн үндсэн зарчимд харшлахгүй бол.

**Тавиндөрөвдүгээр зүйл**  
**Хөндлөнгийн шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрч,**  
**биелүүлэх нэмэгдэл нөхцөлүүд**

Хөндлөнгийн шүүхийн шийдвэрийг доорхи нэмэгдэл нөхцөлүүдийг биелүүлсэн бол энэ Гэрээний 53 дугаар зүйлийн дагуу хүлээн зөвшөөрч, биелүүлнэ. Үүнд:

а/ хэрэв шийдвэрийг хөндлөнгийн шүүхийн эрх хэмжээний тухай бичгээр хийсэн хэлэлцээрийн үндсэн дээр гаргасан бол;

б/ хөндлөнгийн шүүх нь хэрэв тухайн хэлэлцээрээр тогтоосон эрх хэмжээнийхээ дотор шийдвэр гаргасан бол;

в/ хэрэв хөндлөнгийн шүүхийн эрх хэмжээний тухай хэлэлцээр нь нутаг дэвсгэр дээр нь шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэх Хэлэлцэн Тохиролцогч Талын хуулийн дагуу хүчин төгөлдөр байвал.

**Тавинтавдугаар зүйл**  
**Хэлэлцэн Тохиролцогч нөгөө Талын иргэний хувийн**  
**горимд хамаарах шийдвэрийг хүлээн зөвшөөрөх**

Гэрлэлт цуцлах, гэрлэлтийг хүчингүйд тооцох, иргэнийг сураггүй алга болсонд тооцох, нас барсан гэж зарлах, нас барсан үйл баримтыг тогтоох ба эрх олох, үүрэг бий болгох чадварын тухай асуудлаар гарсан Хэлэлцэн Тохиролцогч аль нэг Талын шүүхийн хүчин төгөлдөр болсон шийдвэр нь хэрэв тухайн Хэлэлцэн Тохиролцогч Талын иргэнд хамааралтай байвал уг шийдвэрийг Хэлэлцэн Тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэр дээр байцаан шийтгэх ажиллагаа нэмж явуулахгүйгээр хүлээн зөвшөөрнө.

**Тавинзургадугаар зүйл**  
**Шийдвэр биелүүлэхтэй холбогдсон зардал**

Шийдвэр албадан биелүүлэхтэй холбогдсон зардлын талаар шийдвэрийг нутаг дэвсгэр дээрээ биелүүлж байгаа Хэлэлцэн Тохиролцогч Талын хууль тогтоомжийг хэрэглэнэ.

**Тавиндолоодугаар зүйл**  
**Шийдвэрийг хүлээн зөвшөөрүүлэх буюу**  
**биелүүлэх тухай хүсэлт**

1. Шийдвэрийг хүлээн зөвшөөрүүлэх буюу биелүүлэхийг шийдвэрлүүлэх тухай хүсэлтийг нутаг дэвсгэр дээрээ уг шийдвэрийг биелүүлэх Хэлэлцэн Тохиролцогч Талын эрх бүхий шүүхэд буюу тухайн хэргийн талаар шийдвэр гаргасан анхан шатны шүүхэд шууд гаргаж болох ба уг хүсэлтийг энэ гэрээний 4 дүгээр зүйлд заасан журмаар хүргүүлнэ.

2. Хүсэлтэд доорхи зүйлийг хавсаргана:

а/ шүүхийн шийдвэр, түүний батлагдсан хуулбар, уг шийдвэрт тодорхой заагаагүй бол тэр шийдвэр нь хуулийн хүчин төгөлдөр болсон тухай болон түүнийг биелүүлбэл зохих тухай албан ёсны баримт бичиг;

б/ шүүхийн шийдвэр өөрийн нь эсрэг гарсан зохигч байцаан шийтгэх ажиллагаанд оролцоогүй тохиолдолд түүнд хэргийг хэлэлцэх тухай зохих ёсоор, цаг тухайд нь мэдэгдсэн, түүнчлэн байцаан шийтгэх ажиллагаанд оролцох эрхийн чадваргүй тохиолдолд энэ Гэрээний 53 дугаар зүйлийн "в"-д заасны дагуу төлөөлөгчөө оролцуулах боломжийг зохих ёсоор хангасан тухай лавлагаа;

в/ энэ Гэрээний 5 дугаар зүйлийн 2-т заасан журмын дагуу энэ зүйлийн "а", "б"-д дурдсан баримт бичгийн баталгаатай орчуулга.

3. Хэрэв биелүүлэхийг шийдвэрлүүлэх тухай хүсэлтийг хөндлөнгийн шүүхийн шийдвэрийн үндсэн дээр тавьсан бол шийдвэрийг нь биелүүлбэл зохих хэргийн талаар хөндлөнгийн шүүхийн эрх хэмжээний тухай хэлэлцээрийн баталгаатай орчуулгыг хавсаргавал зохино.

**Тавиннаймдугаар зүйл**  
**Хүлээн зөвшөөрч, биелүүлэх журам**

1. Энэ Гэрээгээр өөр журам тогтоогоогүй бол Хэлэлцэн Тохиролцогч Талын шүүх нь шийдвэрийг хүлээн зөвшөөрүүлэх, биелүүлэх тухай хүсэлтийг өөрийн улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэж, биелүүлнэ.
2. Дээр дурдсан шүүх нь энэ Гэрээний 52-55, 57 дугаар зүйлд заасан нөхцөл бүрдсэн эсэхийг тогтоосноор хязгаарлан, хэрэв эдгээр нөхцөл бүрдсэнийг тогтоовол шийдвэрийг хүлээн зөвшөөрч, зохих ёсоор биелүүлэхийг зөвшөөрнө.

**Тавинесдүгээр зүйл**  
**Шийдвэрийг биелүүлэх цаг хугацааг хязгаарлах**

Энэ Гэрээний 52 дугаар зүйлд заасан шийдвэр нь эд хөрөнгийн тухай хэргийн талаархи хүсэлтэд хамааралтай бөгөөд уг шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон бол энэ Гэрээ хуулийн хүчин төгөлдөр болмогц биелэгдэнэ.

**Жардугаар зүйл**  
**Мөнгө гуйвуулах, эд зүйлийг хилээр нэвтрүүлэх**

Энэ гэрээний заалтууд нь мөнгө гуйвуулах эд зүйлийг хилээр нэвтрүүлэхтэй холбогдсон хэлэлцэн тохиролцогч талуудын хууль тогтоомжийг хөндөхгүй.

**Гуравдугаар хэсэг**  
**Эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа үзүүлэх**

**Жараннэгдүгээр зүйл**  
**Эрүүгийн хэрэг үүсгэх үүрэг**

1. Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэр дээр гэмт хэрэг үйлдсэн өөрийн иргэний талаар хэрэв уг гэмт хэрэг үйлдсэний төлөө Хэлэлцэн тохиролцогч тухайн Талд шилжүүлэн өгөхөөр байвал Хэлэлцэн тохиролцогч энэ Талын шаардлагаар өөрийн орны хууль тогтоомжийн дагуу эрүүгийн хэрэг үүсгэх үүргийг Хэлэлцэн тохиролцогч энэ Талын шаардлагаар өөрийн орны хууль тогтоомжийн дагуу эрүүгийн хэрэг үүсгэх үүргийг Хэлэлцэн тохиролцогч хоёр Тал харилцан хүлээнэ.
2. Эрүүгийг хэрэг үүсгэх тухай шаардлагад гарсан гэмт хэргийн тухай мэдээ сэлтийг агуулсан лавлагаа байгаа бүх нотлох баримт түүнчлэн тухайн гэмт хэрэгт холбогдох хууль тогтоомжийн хуулбарыг хавсаргана.
3. Шаардлага хүлээн авсан Хэлэлцэн тохиролцогч Тал нь эрүүгийн мөрдөн байцаах ажиллагааны дүнг Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талдаа мэдэгдэх үүрэгтэй. Хэрэв уг хэргийн талаар гаргасан таслан шийдвэрлэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсон бол түүний хуулбарыг мэдэгдэлд хавсаргах ёстой.

**Жаранхоёрдугаар зүйл хэсэг**  
**Эрх зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзах**

Дор дурдсан тохиолдолд эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзаж болно.

- а. энэ гэрээний 17 дугаар зүйлд заасан тохиолдолд;
- б. шаардлага хүлээн авсан хэлэлцэн тохиролцогч талын хууль тогтоомж ёсоор тухайн үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй байвал.

**Жарангуравдугаар зүйл**  
**Ял шийтгэл мөрдөн байцаалтын тухай мэдэгдэх**

1. Хэлэлцэн тохиролцогч Тал бүр Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын иргэдийн эсрэг өөрийн шүүхийн байгууллагаас гаргасан хуулийн хүчин төгөлдөр болсон таслан шийдвэрлэх тогтоолд хамаарах мэдээ сэлтийг нөгөө талдаа мэдээлж байна.
2. Энэ зүйлд 1-д заасны дагуу мэдээ сэлтийг энэ гэрээний 5 дугаар зүйлд заасан аль нэг хэлээр үйлдэх бөгөөд мэдээ сэлтийг тусгасан байна.
3. Энэ зүйлийн 1.2-т заасан мэдээ сэлтийг дараахи он эхлэхээс өмнө хэлэлцэн тохиролцогч нөгөө талдаа илгээнэ.
4. Хэлэлцэн тохиролцогч нэг Талын нутаг дэвсгэр дээр урьдчилсан мөрдөн байцаалт явуулж байгаа буюу шүүх хурлаар хэргийг нь хэлэлцэж байгаа Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын харьяатын тухай мэдээ сэлтийг дипломат шугамаар хүргүүлнэ.

**Жарандөрөвдүгээр зүйл**  
**Нэгжлэг хийх эд зүйлийг хураан авах шаардлага**

Нэгжлэг хийх эд зүйлийг хураан авах шаардлагыг түүнийг хүлээн авсан Хэлэлцэн тохиролцогч Талын хууль тогтоомжид зааснаар уг шаардлага нь ял шийтгэл оногдуулж болох гэмт хэрэг үйлдэлд хамаарах буюу уг шаардлагыг хэрэгжүүлэх нь тухайн Талын хууль тогтоомжид харшлахгүй байвал биелүүлнэ.

**Жарантавдугаар зүйл**  
**Шилжүүлэн өгөх үүрэг**

Хэлэлцэн тохиролцогч Талууд энэ Гэрээнд заасан нөхцөл, журмын дагуу тэдний нутаг дэвсгэр дээр байгаа иргэнийг эрүүгийн хариуцлагад татах буюу таслан шийдвэрлэх тогтоолыг биелүүлэх зорилгоор бие биенийхээ шаардлагын дагуу шилжүүлэн өгнө.

**Жаранзургаадугаар зүйл**  
**Хэрэгтнийг шилжүүлэх, үр холбогдол бүхий гэмт хэрэг**

1. Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд Хэлэлцэн тохиролцогч хоёр Талын хууль тогтоомжид зааснаар нэг жилээс дээш хугацаагаар хорих буюу түүнээс хүнд ял оногдуулахаар байвал түүнийг эрүүгийн хариуцлагад татуулахаар шилжүүлэн өгөхийг зөвшөөрч болно.
2. Нэг жилээс дээш хугацаагаар хорих буюу түүнээс хүнд ял шийтгэл оногдуулсан тохиолдолд уг ял шийтгэлийг эдлүүлэхээр шилжүүлж өгөхийг зөвшөөрч болно.

**Жарандолдугаар зүйл**  
**Шилжүүлэн өгөхөөс татгалзах**

Доорхи тохиолдолд шилжүүлэн өгөх шаардлагаас татгалзана:

- а/ шилжүүлэн өгвөл зохих этгээд нь шаардлага хүлээн авсан Хэлэлцэн Тохиролцогч Талын иргэн бол;
- б/ тухайн гэмт хэрэг нь шаардлага хүлээн авсан Хэлэлцэн Тохиролцогч Талын нутаг дэвсгэр дээр гарсан байвал;
- в/ шаардлага хүлээн авсан Хэлэлцэн Тохиролцогч Талын буюу шаардлага тавьсан Хэлэлцэн Тохиролцогч Талын хуулиар хөөн хэлэлцэх хугацаа нь дууссан, өршөөгдсөн, хууль ёсны үндэслэлтэй бусад шалтгаанаар эрүүгийн хэрэг үүсгэж болохгүй буюу таслан шийдвэрлэх тогтоолыг биелүүлэх боломжгүй болсон бол;
- г/ шилжүүлэн өгвөл зохих этгээдийн хувьд, шаардлага хүлээн авсан Хэлэлцэн Тохиролцогч Талын нутаг дэвсгэр дээр гэмт хэргийн талаар гарсан таслан шийдвэрлэх тогтоол буюу хэргийг хэрэгсэхгүй болгох тухай тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсон бол;
- д/ Хэлэлцэн Тохиролцогч аль нэг Талын хуульд зааснаар зөвхөн хохирогчийн гомдлоор үүсгэх эрүүгийн хэрэгт хохирогч өөрөө зохих цагтаа гомдлоо гаргаагүй байвал;
- е/ Хэлэлцэн Тохиролцогч аль нэг Талын хууль тогтоомжоор шилжүүлэн өгөх явдлыг зөвшөөрөөгүй бол.

**Жараннаймдугаар зүйл**  
**Шилжүүлэн өгөхөөс татгалзсан шалтгааныг мэдэгдэх**

Хэрэв шаардлага хүлээн авсан Хэлэлцэн Тохиролцогч Тал шилжүүлэн өгвөл зохих этгээдийг шилжүүлэн өгөхөөс татгалзвал ийнхүү татгалзсан шалтгааныг Хэлэлцэн Тохиролцогч нөгөө Талд мэдэгдэнэ.

**Жаранесдүгээр зүйл**  
**Шилжүүлэн өгөх тухай шаардлага**

1. Шаардлагыг бичгээр үйлдэнэ.
2. Шаардлагад хавсаргах зүйл:
  - а/ баривчлах буюу хүчин төгөлдөр болсон таслан шийдвэрлэх тогтоолын баталгаатай хуулбар;
  - б/ шүүгдэгч буюу ялтны хувийн байдлыг тодорхойлох баримт бичиг, иргэний харьяаллын тухай буюу хувийн байдалтай холбогдсон бусад мэдээ сэлт;
  - в/ шүүгдэгч буюу ялтны танигдах онцлогийн тухай тодорхойлолт, түүнчлэн бололцооны хирээр түүний гэрэл зураг, хурууны хээ;
  - г/ гарсан гэмт хэргийн тодорхойлолт, хуулийн зүйл анги;
  - д/ шаардлага тавьж байгаа Хэлэлцэн Тохиролцогч Талын эрүүгийн хуулийн тухайн гэмт хэргийг зүйлчлэн ангилж байгаа заалт.

3. Хэрэв шаардлага тавьж байгаа Хэлэлцэн Тохиролцогч Талын өгсөн мэдээ сэлт нь шилжүүлэн өгөх тухай шийдвэр гаргахад хангалтгүй байвал шаардлага хүлээн авсан Хэлэлцэн Тохиролцогч Тал шаардлагатай нэмэгдэл мэдээ хүсэж, уг мэдээг ирүүлбэл зохих хугацааг тодорхойлно. Энэ хугацааг хүсэлтээр сунгаж болно.

**Далдугаар зүйл**  
**Шилжүүлэн өгөх этгээдийг баривчлах**

Энэ Гэрээнд заасан нөхцлийн дагуу шилжүүлэн өгөх тухай шаардлага хүлээн авсан Хэлэлцэн Тохиролцогч Тал шилжүүлэн өгвөл зохих этгээдийг нэн даруй эрэн сурвалжилж олох, шаардлагатай тохиолдолд баривчлах арга хэмжээ авна.

**Даланнэгдүгээр зүйл**  
**Түр хорих**

1. Хэлэлцэн Тохиролцогч Талын эрх бүхий байгууллага шилжүүлэн өгвөл зохих этгээдийг баривчлах тухай тогтоол гарсан буюу шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсныг дурдаж, уг этгээдийг шилжүүлэн авах тухай шаардлага явуулах гэж байгаагаа мэдэгдэж, хүссэнийг үндэслэн шилжүүлэн авах тухай шаардлага ирэхээс өмнө түүнийг баривчилж болно. Ийм хүсэлтийг шуудан, цахилгаанаар явуулах болон утсаар ярих зэргээр тавьж болно.
2. Хэрэв энэ Гэрээний 66 дугаар зүйлд дурдсан гэмт хэргийг Хэлэлцэн Тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт үйлдсэн гэдэг лавтай үндэслэл байвал энэ зүйлийн 1-д заасан шаардлага ирээгүй байсан ч Хэлэлцэн Тохиролцогч нэг Талын эрх бүхий байгууллага өөрийн нутаг дэвсгэрт байгаа этгээдийг баривчилж болно.
3. Энэ зүйлийн 1, 2-т зааснаар баривчилсан тухайгаа Хэлэлцэн Тохиролцогч нөгөө Талд нэн даруй мэдэгдэнэ.
4. Хэрэв энэ Гэрээний 69 дүгээр зүйлийн 2-т заасан баривчлах тухай шаардлага болон түүний хавсралт нь хорих тухай мэдээ сэлт хүлээн авсан өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд ирэхгүй бол түр баривчилсан этгээдийг суллаж болно.

**Даланхоёрдугаар зүйл**  
**Баривчлагдагчийг суллах**

Хэрэв шаардлага тавьж байгаа Хэлэлцэн Тохиролцогч Тал шилжүүлэн өгвөл зохих этгээдэд хамаарах нэмэгдэл мэдээг энэ Гэрээний 69 дүгээр зүйлийн 3-т заасан хугацаанд өгөөгүй бол шаардлага хүлээн авсан Хэлэлцэн Тохиролцогч Тал баривчлагдсан этгээдийг суллана.

**Далангуравдугаар зүйл**  
**Шилжүүлэн өгвөл зохих этгээдийг шилжүүлэх**

1. Шилжүүлэн өгөх шаардлага хүлээн авсан Хэлэлцэн Тохиролцогч Тал уг шаардлагыг зөвшөөрч байгаа бол шилжүүлэн өгвөл зохих этгээдийг шилжүүлэх газар, цаг хугацааг шаардлага тавьж байгаа Хэлэлцэн Тохиролцогч Талд мэдэгдэнэ.
2. Хэрэв шаардлага тавьсан Хэлэлцэн Тохиролцогч Тал шилжүүлэн өгөхөөр болзсон өдрөөс хойш тогтоосон газарт нэг сарын хугацаанд шилжүүлэн өгөх этгээдийг хүлээн авахгүй бол уг этгээдийг суллана.
3. Энэ Гэрээний 71 дүгээр зүйлийн 4, 72 дугаар зүйл, энэ зүйлийн 2-т зааснаар баривчилсан этгээдийг сулласан явдал нь шилжүүлэх өгөх тухай шаардлага дахин тавьсан нөхцөлд баривчлах, шилжүүлэн өгөх асуудлыг сэргээхэд саад болохгүй.

**Даландөрөвдүгээр зүйл**  
**Шилжүүлэн өгөхийг хойшлуулах**

Шаардлага хүлээн авсан Хэлэлцэн Тохиролцогч Талын нутаг дэвсгэр дээр шилжүүлэн өгвөл зохих этгээд эрүүгийн хариуцлагад татсан буюу өөр хэргийн учир ял шийтгүүлсэн бол эрүүгийн хэргийг шийдвэрлэх буюу оногдуулсан ялын хугацааг эдэлж дуусах хүртэл шилжүүлэн өгөхийг хойшлуулж, ийнхүү хойшлуулсан шалтгааны тухай Хэлэлцэн Тохиролцогч нөгөө Талд мэдэгдэнэ.

### **Далантавдугаар зүйл Түр шилжүүлэн өгөх**

Хэрэв шилжүүлэн өгөхийг хойшлуулахад эрүүгийн хэргийн хөөн хэлэлцэх хугацаа өнгөрөх буюу гэмт хэргийг мөрдөх явдалд ноцтой хор хохирол учруулахаар байвал шилжүүлэн өгвөл зохих хэлэлцэн Тохиролцогч нөгөө Талын үндэслэл бүхий хүсэлтээр эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулахтай холбогдуулан түр шилжүүлэн өгч болно. Шаардлага тавьсан Хэлэлцэн Тохиролцогч Тал шилжүүлэн өгсөн этгээдийг хүлээн авсан өдрөөс хойш гурван сарын дотор уг этгээдийг буцаан өгөх үүрэгтэй. Бодитой үндэслэлээр энэ хугацааг сунгаж болно.

### **Даланзургадугаар зүйл Шилжүүлэн өгөх журам**

Хэрэв энэ Гэрээгээр өөр журам тогтоогоогүй бол шилжүүлэн өгөх, баривчлахдаа шаардлага хүлээн авсан Хэлэлцэн Тохиролцогч Талын хууль тогтоомжийг хэрэглэнэ.

### **Даландолдугаар зүйл Шилжүүлэн өгсөн этгээдийг мөрдөх хязгаар**

1. Шилжүүлэн өгсөн этгээдийг ийнхүү шилжүүлэн өгөхөөс өмнө үйлдсэн өөр хэрэгт холбогдуулан шаардлага хүлээн авсан Хэлэлцэн Тохиролцогч Талын зөвшөөрөлгүйгээр эрүүгийн хариуцлагад татах, шийтгэх, эсхүл баривчлах буюу гуравдахь улсад шилжүүлэн өгч болохгүй.
2. Зөвшөөрөл шаардахгүй тохиолдол:
  - а/ шилжүүлэн өгсөн этгээд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулж дууссан буюу ял эдэлж дууссанаас хойш нэг сарын дотор түүнийг шилжүүлэн авсан Хэлэлцэн Тохиролцогч Талын нутаг дэвсгэрээс гарч яваагүй бол, харин уг этгээд шаардлага тавьсан Хэлэлцэн Тохиролцогч Талын нутаг дэвсгэрээс өөрийн буруу биш шалтгаанаар явж чадаагүй байсан хугацааг дээр дурдсан хугацаанд оруулан тоолохгүй;
  - б/ шилжүүлэн өгсөн этгээд шаардлага тавьсан Хэлэлцэн Тохиролцогч Талын нутаг дэвсгэрээс яваад дараа нь өөрийн сайн дураар эргэж ирсэн байвал.

### **Даланнаймдугаар зүйл Шилжүүлэн өгөх тухай хэд хэдэн улсын шаардлага**

Хэрэв тодорхой буюу янз бүрийн гэмт үйлдлийн улмаас шилжүүлэн өгөх тухай шаардлага хэд хэдэн улсаас ирвэл шаардлага хүлээн авсан Хэлэлцэн Тохиролцогч Тал шилжүүлэн өгөх этгээдийн харьяалал, түүнчлэн хэргийн хүнд, хөнгөний байдал, үйлдсэн газрыг харгалзан үзэж аль шаардлагыг хангавал зохихыг шийдвэрлэнэ.

### **Даланесдүгээр зүйл Эд зүйлийг шилжүүлэх**

1. Гэмт этгээдийг шилжүүлэн өгөх үедээ түүний гэмт хэргийн замаар олсон бүх эд зүйл, түүнчлэн уг эд зүйлийг худалдаж олсон мөнгө, үнэт зүйл, мөн эрүүгийн хэргийн явцад нотлох баримтын үүрэг гүйцэтгэх болон бусад эд зүйлийг Хэлэлцэн Тохиролцогч Талуудын эрх бүхий байгууллага бололцооны хирээр тусгайлан шаардуулахгүйгээр нэг нэгэндээ шилжүүлэн өгнө.
2. Шилжүүлэн өгвөл зохих гэмт этгээд нас барсан буюу оргосны улмаас шилжүүлэн өгөх бололцоогүй болсон тохиолдолд ч энэ зүйлийн 1-д заасан эд зүйлийг шилжүүлэн өгнө.
3. Эдгээр эд зүйлийн хувьд шаардлага тавьсан Тал буюу гуравдахь улсын эрх халдашгүй хэвээр байна. Хэрэв ийм эрхтэй бол шүүн таслах ажиллагаа дууссаны дараа эдгээр эд зүйлийг эргүүлэн авах эрх бүхий этгээдэд шилжүүлэн өгөх зорилгоор шаардлага хүлээн авсан Хэлэлцэн Тохиролцогч Талд нэн даруй үнэ төлбөргүйгээр эргүүлэн өгвөл зохино.
4. Хэрэв эдгээр эд зүйл нь эрүүгийн байцаан шийтгэх өөр ажиллагаанд хэрэгцээтэй гэж үзвэл шаардлага хүлээн авсан Хэлэлцэн Тохиролцогч Тал эдгээр эд зүйлийг түр үлдээх буюу богино хугацаанд эргүүлэн өгөх шаардлагатайг дурьдан шилжүүлж болно.

### **Наядугаар зүйл**

### **Дамжуулан өнгөрүүлэх**

1. Хэлэлцэн Тохиролцогч Тал Хэлэлцэн Тохиролцогч нөгөө Талын хүсэлтээр гуравдахь улсаас нөгөө Хэлэлцэн Тохиролцогч Талд шилжүүлэн өгөх этгээдийг өөрийн нутаг дэвсгэрээр дамжуулан өнгөрүүлэхийг зөвшөөрөх үүрэг хүлээнэ. Хэрэв энэ Гэрээгээр шилжүүлэн өгөх тухай заагаагүй тохиолдолд Хэлэлцэн Тохиролцогч Талууд дамжуулан өнгөрүүлэх үүрэг хүлээхгүй.
2. Дамжуулан өнгөрүүлэх тухай шаардлагыг шилжүүлэн өгөх шаардлагын адил журмаар үйлдэж явуулна.
3. Шаардлага хүлээн авсан Хэлэлцэн Тохиролцогч Тал шилжүүлэн өгч байгаа этгээдийг дамжуулан өнгөрүүлэхдээ өөрийн нутаг дэвсгэр дээрээс орлуулахгүй байх явдлыг хангасан байвал зохино.

### **Наяннэгдүгээр зүйл**

#### **Шилжүүлэн өгөх, дамжуулан өнгөрүүлэхтэй холбогдсон зардал**

1. Шилжүүлэн өгөх зардлыг уг зардал нутаг дэвсгэр дээр нь гарсан Хэлэлцэн Тохиролцогч Тал хариуцна. Харин шилжүүлэн өгөх этгээдийг агаарын тээврээр хүргэхтэй холбогдсон зардлыг шаардлага тавьж байгаа Хэлэлцэн Тохиролцогч Тал хариуцна.
2. Дамжуулан өнгөрүүлэхтэй холбогдсон зардлыг шилжүүлэн өгөх тухай шаардлага тавьсан Хэлэлцэн Тохиролцогч Тал хариуцна.

### **Наянхоёрдугаар зүйл**

#### **Эрүүгийн хэргийн мөрдөн байцаалтын дүнгийн тухай мэдэгдэх**

Хэлэлцэн Тохиролцогч Талууд шилжүүлэн өгсөн этгээдийн талаар явуулсан эрүүгийн мөрдөн байцаалтын дүнгийн тухай бие биедээ мэдээлж байна. Хэрэв шилжүүлэн өгсөн этгээд шийтгүүлсэн бол хүчин төгөлдөр болсон таслан шийдвэрлэх тогтоолын хуулбарыг хүргүүлнэ.

### **ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ**

#### **Төгсгөлийн заалтууд**

#### **Наянгуравдугаар зүйл**

1. Энэ гэрээг соёрхон батална.
2. Батламж жуух бичгийг Улаанбаатар хотод солилцоно.

#### **Наяндөрөвдүгээр зүйл**

1. Энэ Гэрээ нь батламж жуух бичиг солилцсоноос хойш гучин хоногийн дараа хүчин төгөлдөр болох бөгөөд таван жилийн хугацаанд хүчин төгөлдөр хэвээр байна.
2. Хэрэв Хэлэлцэн Тохиролцогч аль нэг Тал Гэрээний хугацаа дуусахаас зургаан сараас доошгүй хугацааны өмнө Гэрээг цуцлах тухайгаа бичгээр мэдэгдээгүй бол энэ Гэрээ тухай бүр таван жилийн хугацаагаар сунгагдана.

Гэрээг бичгээр цуцалсан өдрөөс хойш нэг жил өнгөрмөгц уг Гэрээг хүчин Төгөлдөр бус гэж тооцно. Энэ Гэрээг Серб-Хорват, Монгол, Орос хэлээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд гурван эх хувь тус бүр адил хүчинтэй байна.

Гэрээг тайлбарлахад маргаан гарвал орос хэлээр эх хувийг баримтална. Хэлэлцэн Тохиролцогч Хоёр Талын бүрэн эрхт төлөөлөгчид харилцан тохиролцсоноо нотлон энэ Гэрээнд гарын үсэг зурж, тамга дарав.

1981 оны 6 дугаар сарын 8-ны өдөр Улаанбаатар хотод үйлдэв.